



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/24

Хархорин сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8.1, 9.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүрийн хавар, намар мал сүрэгт хийгддэг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүд: Ц.Пүрвээ ("Дэлийн бүрд" мал эмнэлгийн эзэн)
А.Сайнбилэг ("Аяган зураа" мал эмнэлгийн захирал)
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)
П.Нэндором (8 дугаар багийн Засаг дарга)

2. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын хаврын ажлыг 2024 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр, намрын вакцинжуулалтыг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны өдрийг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэн, дүн мэдээг тухай бүр Засаг даргад танилцуулахыг (Ц.Пүрвээ), (А.Сайнбилэг) нарт тус тус даалгасугай.

3. Вакцинжуулалтын ажлын зарыг малчдад хүргэж, товлосон газарт мал сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон газар тогтоосон хугацаанд вакцинжуулалтын арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэн, малчдад үүрэг болгосугай.

401100047

4.Вакцинжуулалтын ажлын явц, технологийн мөрдөлт, зохион байгуулалт, мал сүргийн хамрагдалтад байнгын хяналт тавин ажиллаж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулан ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Нарангарав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ